

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Монголын геологи хайгуулын нэгдсэн системтэй боллоо

Д.МОНХ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсын геологийн мэдээллийн каталоги системийг танилцуулав. Энэхүү системийг **Австрали** улсын Засгийн газрын "Америк" хетелберийн санхүүжилтээр "Оюуны цоморлиг импекс" компанийн мэргэжилтнүүд таван сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Монгол Улсын геологийн мэдээллийн бүх тайланг онлайн орчинд түргэн шуурхай хэрэглэж ашиглах боломжийг бүрдүүлж байгааг тус компанийн Газарзүйн сангийн мэргэжилтэн Д.Дэжидмаа онцолж байлаа. Үүнийг зөвхөн геологийн салбарынхан төдийгүй сонирхсон хүн бүхэн үзэж судлах боломжтой юм. Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-ын үйл ажиллагааны хетелбөрт тусгасан геологийн мэдээ, мэдээллийг олон улсын жишигт нийцүүлж, хэрэглэгчдэд хүндрэлгүй, бодитоор хүргэх Монгокат системийг энэ оны деревдүгээр улирлаас эхлэн ашиглах юм. "Энэхүү систем нь УУХҮЯ болон АМГТГ-ын Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан байгуулах ажлын төлөвлөгөөний хурзэнд хийсэн томоохон хетелberийн нэг болж байна" гэж УУХҮЯ-ны Терийн нарийн бичгийн дарга Г.Нандинтушиг онцолсон юм.

Монгокат систем нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд геологийн мэдээллийн эх үүсвэрийн талаарх төвч мэдээллийг авах боломжтой юм байна.

Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг нь цахим сүлжээний орчинд орон зайн хайлт хийх боломжийг олгож байгаа газарзүйн мэдээллийн систем бөгөөд энэ нь дэлхий дахины 90 хувь нь ашигладаг Arcgis программд суурилсан, орчин үеийн хамгийн хүчирхэг систем болохыг "Оюуны цоморлиг импекс" компанийн захирал, доктор С.Амарсайхан онцолж байлаа. Хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь геологийн мэдээллийн тухай хураангуйг түлхүүр үгээр хайх метадата-каталоги систем. Энэ нь Geonetwok программд суурилсан, мэдээллийг хэрхэн, хэн бэлтгэсэн тухай өгүүлдэг бөгөөд еренхийдээ Монгокат систем нь сансрын зураг ашиглан, ашигт малтмалын орд, тэдгээрийн суурь болон жижиг, дунд геологийн зураглалыг харуулдаг аж. Төвчхондоо, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа төрөл бүрийн ашигт малтмалын геологи хайгуулын ажлын үр дүнг төвч бөгөөд тодорхой харуулах мэдээллийн сан юм. Энэхүү санд 1914 оноос хойш Монгол Улсад хувийн болон териийн санхүүжилтээр хийсэн геологи хайгуулын бүх ажил, түүний үр дүнгийн тухай мэдээлэл хуримтлагдаж байна.